

2024.01.23

1. Монгол Улсын хууль

Ойн тухай /Шинэчилсэн найруулга/
2012-05-17 Дугаар 2022.06.03

1.1 Ой, хээрийн түймрээс хамгаалах, тэмцэх арга хэмжээний зардлыг аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагааны төсөвт жил бүр тусгадаг. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт, сургалт сурталчилгааны ажлыг ГХУСАЗөвлөл, аймгийн ОБГазар, БОАЖГазар, ОХБЦГХЗ, ой бүхий сумдын ЗДТГазар, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар хамтран зохион байгууллаа. Урьдчилан сэргийлэх, мэдээ, мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулснаар 2023 онд Өвөрхангай аймагт ойн түймэр гараагүй бөгөөд хээрийн түймрийн дуудлага 2 бүртгэгдсэн байна.

2. МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг

Засгийн газарт чиглэл өгөх тухай
(Тэрбум мод)
2021-10-04 Дугаар 2021_58

2.1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 оны бүх нийтээр мод тарих хавар, намрын өдрүүдийг Өвөрхангай аймагт 2023 оны 05, 10 дугаар саруудад зохион байгуулж тарьц суулгац нийлүүлэх үзэсгэлэн худалдааг Арвайхээр, Хархорин сумдад зохион байгууллаа. 2023 оны 10 сарын 25-ны байдлаар Өвөрхангай аймагт хаврын тарилтаар 256000, намрын тарилтаар 70466, нийт 326800 орчим мод, бут тарьж доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулалт, БСУТАжлаар 147000 ш, төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, айл өрх, албан байгууллагууд 108500 ш, цөлжилт газрын доройтлыг бууруулах чиглэлээр 55346 ш, агро ойн аж ахуй хөгжүүлэх зорилгоор 14620 мод тарьсан байна. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 онд хэрэгжүүлсэн ажлын тайланг ЕТГазар, Ойн газарт хүргүүллээ. 2023 онд ойжуулалт 43 га, байгалийн сэргэн ургалтад туслах ажил 15 га, ойн зурвас 40 га, шинээр байгуулсан ногоон байгууламж 35 га талбайгаар нэмэгдсэн байна.

Төв суурин газрын ногоон байгууламж нэмэгдүүлэх, мод тарих, ойг нөхөн сэргээх, ойн зурвас байгуулах ажилд 2023 онд сумдын ОНХСан, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 976 орчим сая төгрөг, улсын төсвөөс 512,0 сая төгрөг, төсөл хөтөлбөр, хувийн хэвшлээс 55.5 сая төгрөг, нийт 1,5 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Арвайхээр суманд 2023 онд мод тарих төвлөрсөн байршил болох 23 га талбай бүхий “Баян намсрай” цэцэрлэгт хүрээлэнг шинээр байгуулж хавар намрын мод тарих өдрүүдээр 11000 орчим мод тарилаа. “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд мод тарих арга хэмжээний зардлыг улс, орон нутгийн төсөв, айл өрх, албан байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн хөрөнгөөр санхүүжүүлж байна.

Байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, мод бут тарих, экологийн боловсрол олгох чиглэлээр иргэд, өсвөр үеийнхэнд зориулсан сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, 2023 оны байдлаар 14 суманд 24 удаагийн сургалт, 6 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, 2900 орчим иргэн хамрагдсан.

Орхон, Онги, Таац, Арвайхээр сумын Дайрга, Дэлгэрэх гол дагуу мод тарьсан, үржүүлгийн газар байгуулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэд усалгаанд гадаргын ус хуримтлуулж ашиглаж байна. Шинээр байгуулсан ойн зурвас, мод үржүүлгийн газар, ногоон байгууламжид усны хэмнэлттэй технологи дуслын услагаа, намираа услалтын систем ашиглаж шинэ техник, технологи нэвтрүүлэх ажил жилээс жилд өргөжиж байна.

Өвөрхангай аймагт Мод үржүүлгийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийг хангай, тал хээр, говийн бүсчлэлээр төрөлжүүлж тухайн бүс нутгийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, агро техникийн зөвлөмж, орчин үеийн техник, технологи

нэвтрүүлж ажиллах зөвлөмжөөр ханган ажиллаж байна. Тус аймгийн хангайн бүсэд Бат-Өлзий, Хужирт, Хархорин, Зүүнбаян-Улаан, тал хээрийн бүсэд Хархорин, Арвайхээр, Тарагт, говийн бүсэд Баруунбаян-Улаан суманд мод үржүүлгийн үйл ажиллагаа эрхэлдэг 19 аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна.



Аймгийн хэмжээгээр төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ 2020 оны суурь түвшингээс 85 гар нэмэгдэж нийт 216,8 га болж нэмэгдсэн бөгөөд Арвайхээр сумын ногоон байгууламж 45 га талбайгаар нэмэгдлээ.

Арвайхээр суманд 2022 онд 12 га цэцэрлэгт хүрээлэн, төв авто замын дагуу 1.5 км урт ойн зурвас, 2023 онд “Баян намсрай” 23 га цэцэрлэгт хүрээлэн шинээр байгуулагдлаа.

3. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж

3.1. Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40

Бат-Өлзий суманд улсын төсвийн 6,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Юу Зэт Эрдэнэ” ХХК 5090м цэвэр усны шугам сүлжээ, цэвэр усны гүний худгийн 2 барилга, усан сан, хоногт 100 м.куб бохир зайлуулах чадалтай цэвэрлэх байгууламж, 3557м ариутгах татуургын шугам, 2445м гадна дулаан хангамжийн шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэсэн.

Уянга суманд улсын төсвийн 6,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Аум Алт” ХХК хүн амын усан хангамжийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгэж 2 худаг гаргаж 2000 метр цэвэр усны шугам, 2680 м бохир усны шугамын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хайрхандулаан сумын хүн амын ундны усны нөөцийг тогтоох ажлыг тусгай зөвшөөрөл бүхий “Цагаан зуун” ХХК-иар гүйцэтгүүлж, Бат-Өлзий сумын төвийн ундны усны нөөцийг тогтоолгосон. Хужирт суманд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 3 тэрбум 298 сая төгрөгөөр сумын нэгдсэн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг “Санжат” ХХК гүйцэтгэсэн. Үүнд 50м гүнтэй цэвэр усны гүний худаг гаргаж, 3120 м урттай бохир усны шугам тавих, захиргаа, уурын зуухны барилга байгууламжийн ажил хийгдэж ашиглалтад орсон.

Усны зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор 2023 онд шинээр 6 аж ахуйн нэгжийг тоолууржуулж, 11 аж ахуйн нэгжийн тоолуурыг сольж 19 аж ахуйн нэгжийн тоолуурыг баталгаажуулсан. Арвайхээр сумын төвийн дундуур урсдаг Дэлгэрэх голын голдирлын 2,3 км газар шулуутгаж, мөн үерийн хамгаалалтын далан, үерийн ус хуримтлуулах хөвийн хэвийн үйл ажиллагааг Арвайхээр сум хариуцан ажиллаж байна. 2023 онд уг хөвийн засвар үйлчилгээг “Арвайхээр тохижилт, үйлчилгээ” ОНӨААТҮГазар хариуцан гүйцэтгэж, одоогийн байдлаар 1600м³ лагыг цэвэрлэн зайлуулаад байна. Хархорин суманд гэр хорооллыг үерээс хамгаалах 1,2 км далан сувгийн ажил хийгдэж бүрэн ашиглалтад орсон.

Арвайхээр суманд 07 дугаар сард усархаг аадар бороо орж их хэмжээний үер бууж гамшгийн хэмжээнд хүрсэн Дэлгэрэх голын голдирол, далан хөвөө, зам гүүрний эвдрэлийг яаралтай сэргээн засварласан. 2024 онд хийгдэхээр төлөвлөгдсөн Эмтийн сайр орчимд үерээс хамгаалах, ус хуримтлуулах боомт, Онгийн гол дагуух усан хангамжийн эх үүсвэрүүдийг үерээс хамгаалах далан, Дэлгэрэх голын эх орчимд орчимд үерээс хамгаалах, ус хуримтлуулах боомт, Нарийнтээл сумын үерийн усны далан, шуудууны зураг төслүүдийг боловсруулаад байна.

3.2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай

2021-09-30 Дугаар 2021_03

Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсрол олгох зорилгоор 2021-2023 онд орон нутгийн "Соёмбо" болон МҮОНР телевиз, ӨВ live.mn сайт, эх бэлтгэлийн "Оюунана брэнд" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, 156 эх бэлтгэл, сурталчилгааны постер, 55 удаагийн мэдээ, 15 сэдвийн сурвалжилга, 10 шторк, шууд live нэвтрүүлгүүдийг хийлгэж байгууллагын цахим хуудас болон сайтаар иргэд олон нийтэд хүргэж, иргэд, өсвөр үеийнхэнд 25 удаагийн сургалт, 2 удаагийн чуулган зохион байгууллаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарынн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 92,2 хувьтай хэрэгжсэн байна.

ХЯНАСАН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА

Г.БАЯСГАЛАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД
АЖИЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЗОЛЗАЯА